



БИДНИЙ ТУХАЙ

БЦНТ ХХК нь 2006 оноос идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд чанартай, баталгаатай, шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр хэрэглэгчидээ хангаж ажиллах гэсэн зарчмыг баримтлан, ОХУ, БНХАУ, Турк, Польш зэрэг улс орнуудаас сантехникийн бараа материал, ган хэвлэмэл радиатор зэргийг импортлон хэрэглэгчиддээ найдвартай, өргөн сонголттойгоор нийлүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлсээр тасралтгүй 14 дэх жилдээ ажиллаж байна.

БЦНТ ХХК

БАРИЛГЫН МАТЕРИАЛ ХУДАЛДАА

Салбар 1 : Сүхбаатар дүүрэг, Цагдаагийн гудамж, 100 айл барилгын материалын зах, Алтан Түрүү барилга 1 тоот

Салбар 2: Гурвалжингийн гүүр, ВIG барилгын материалын худалдааны төв

Салбар 3: БЗД, Цайз барилгын материалын төв Б1 давхарт
Утас:99285924, 99061567

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЗАХИАЛГА

Төв оффис:Баянзүрх дүүрэг, Оффичеруудын ордон,Wolrd Mongolia Building 5 тоот
Утас:77401717,99030279
E-Майл: bcnt@inter-trade.mn



БИДНИЙ ЗОРИЛТ

Бид үйл ажиллагаа өргөжин тэлсээр сантехникийн бараа материалаар зогсохгүй мэдээлэл технологи, роботик, цахилгаан хангамж холбоо, хэмжүүрийн багаж тоног төхөөрөмж зэргийг АНУ, УНГАР, ХБНГУ,БНХАУ зэрэг улсуудаас захиалагчийн техникийн шаардлагын дагуу, тохирсон хугацаанд найдвартай нийлүүлээд зогсохгүй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, баталгаат эд ангиудын худалдаа зэргийг өөрсдийн салбар нэгжүүдээр тогтмол худалдаалж байна.



САНТЕХНИК

Хэрэглэгчдийн шаардлага хэрэгцээнд нийцсэн Монгол улсын стандарт нормыг бүрэн хангахуйц хямд үнэтэй, сайн чанарын сантехникийн бараа материалыг тасралтгүй 14 дэх жилдээ импортлон дотоодын зах зээлд найдвартай, тасралтгүй ханган нийлүүлсээр байна. Хэрэглэгчдэдээ худалдан авалтын дараах баталгаа, найдвартай ажиллагааг хангах үүднээс бид үргэлж албан ёсны реселлер эсхүл Монгол дахь түнш төлөөлөгчийн эрх үүргийн дагуу худалдаа үйлчилгээг харилцагчдадаа үзүүлдэг.

БИД АЛБАН ЁСНЫ ДИСТРОБЮТОР



ГАН ХООЛОЙ
ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ

БНХАУ улын TOBO Групп нь ган төмөр, цайрдсан төмөрийн хүнд үйлдвэр бөгөөд ган хоолой холбох хэрэгслийг үйлдвэрээс шууд манай компаниар дамжин хэрэглэгчдийн гарт очдог нь хямд үнэ өргөн сонголтын үндэс болдог.



БОХИР УС ЗАЙЛУУЛАХ
ХУВАНЦАР ХООЛОЙ

ОХУ Ростурпластын бохир усны PVC болон цэвэр усны хангамжийн PPR хуванцарын хоолойг бид үйлдвэрийн дотоодын зах зээлд нийлүүлж байна.

mastas

ГАН ХЭВЛЭМЭЛ
РАДИАТОР

Mastas 1959 онд байгуулагдсан бөгөөд панел радиаторын үйлдвэрлэлийн салбарт тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж улам өсөн дэвжиж байна. Турк улсын MASTAS группын ган хэвлэмэл радиатор нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэгч брэнд болоод байна. Монгол улсад 2013 оноос хойш 60 гаруй мянган ширхэг MASTAS Брендийн ган хэвлэмэл радиатор худалдаалагдсан байна.



ПОЛИЭТИЛИН
ХООЛОЙ

Итали улсын UNIDELTA компани 1973 оноос усны суваг, хийн шугам, усалгааны систем, галын шугам, ус зайлуулах систем болон халаалтын системд зориулж полиэтилин хоолой хийж эхэлсэн. UNIDELTA нь 40 жилийн хугацаанд тасралтгүй өсөн дэвжиж, өнөөдөр бүх бараа бүтээгдэхүүнүүд нь (UNI EN ISO 9001:2008) чанарын стандартыг хангасан сантехник халаалтын систем тэргүүлэгч үйлдвэр болсон юм.



ЭРГЭЛТИЙН БОЛОН
ӨРГӨЛТИЙН НАСОСУУД



ТЭЛЭЛТИЙН САВ



ЯЛТАСТ БОЙЛЕР



АВТОМАТ ХААЛТУУД
АКТИВАТОР УДИРДЛАГУУД



ДУЛААНЫ УЗЕЛЬ

Бид бүх төрлийн барилга байгууламжын дулааны узелийн ялтсан бойлер **Danfoss** **SIEMENS** брендийн автомат хаалтууд, **BestTank** тэлэлтийн сав худалдаалаад зогсохгүй, хэрэглээнд тохирсон насосын сонголт болон автоматжуулалтыг хэрэглэгч харилцагч байгуулагдаа санал болгосоор ирсэн.



ONE STOP SUPPLIER- ЗАХИАЛГАТ ХУДАЛДАА

Бид Монгол улсад төдийлөн өөрсдийн салбар, төлөөлөгчийн газараа байгуулж амжаагүй дэлхийн томоохон брендүүдийн барилга, мэдээлэл технологи, хэмжилтийн болон угрсралтын тоног төхөөрөмжийн худалдааг хэрэглэгчийн хүсэлд нийцүүлэн сонголт хийн захиалгаар нийлүүлэх үйл ажиллагааг үйлчилгээндээ нэвтрүүлээ.

БИДНИЙ ТОМООХОН АЖЛУУДААС

- Захиалагч: ШУТИС
2019 он Монголын хамгийн анхны манипулятор робот-1 иж бүрэн комм ABB IRB120 Robot
- Захиалагч: ШУТИС
2019 он бүрэн програмчлагдах сургалтын ICreate 2 Robot-4 иж бүрэн робот

- Захиалагч: Перфект
Солюшн энд Инженеринг ХХК
2019 он өндөр хүчдэлийн явуулын лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж

- Захиалагч: Гаалийн ерөнхий газар
2020 он гаалийн байцаагчдын иж бүрэн смарт төхөөрөмж үүнд. Энгэрийн Камер, Иж бүрэн GPS, Порталь X-Ray

- Захиалагч: ДЦС-4
2020 он Сүлжээ холбооны материал

- Захиалагч: Дархан Уул аймгын засаг даргын тамгын газар
2020 он бүрэн автомат аспалтан зам засах Python 5000 Pothole Patcher машин

гэх мэт барилга, мэдээлэл технологи, зам засвар, барилгын материалын бүх төрлийн бараа материалыг хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн олон улсын зах зээл дээрээс түргэн шуурхай оруулж ирдгээрэй давуу талтай.